



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 4/47

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Үнэлгээний хорооны журам шинэчлэн батлах тухай сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаал, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвижих төглийг хашаажуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хороон дарга: (О.Уранзаяа) Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: (Г.Баасанжав) Хүний нөөцийн ажилтан

Гишүүд: (Д.Найрамдал) Хүмүүнлэг сургуулийн багш

(П.Энхтуяа) Иргэний төлөөлөл

(Ж.Базарсад) ХТГазрын инженер

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (О.Уранзаяа)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

